

XIII ЗУУНЫ МОНГОЛ БА ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ОРНУУДЫН ХУДАЛДАА СОЁЛЫН ХАРИЛЦАА

*С.Дашцэвэл**

1. Монголын эзэнт гүрний Зүүн Өмнөд Ази дахь бодлого

XIII зууны сүүлийн хагаст Монголын Эзэнт гүрний гадаад дотоод байдал Чингис хааны үеийнхээс нэлээд өөр болсон. Юуны өмнө Чингис хаан эзлэн авсан өргөн уудам нутгаа уламжлал ёсоор хөвгүүддээ өмч болгон хүртээсэн байлаа. Үүний дүнд Евроазийг дамнасан Эзэнт гүрний дотор хэд хэдэн автономи улс бий болоод байв. Гэвч Чингис хааны үр ач нар суурьшсан газар нутагтаа монголын төрийн уламжлалт бодлогыг хэрэгжүүлж түүний аюулгүй байдлыг бэхжүүлэн хил хязгаараа тэлсээр байв. Энэ бүхэн дэлхийн талыг эзэгнэсэн Эзэнт гүрэн бий болох үндсийг тавьжээ. 1260 онд Монгол, Уйгур, Төвд, Тангад, умард Хятадын уудам нутгийг хамарсан Юан гүрэн бий болж, монгол гүрний гал голомтыг сахисан эцэг Тулуйн өвийг залгамжилж Хубилай хаан ор суув. Энэ үед Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүнд байсан Цагаадайн улс, Алтан ордоны улс, Ил хаадын улс харьцангуй бие даасан байдалтай болсон ч Чингис хааны үеэс улбаатай төрийн нэгдсэн бодлогод захирагдаж байсныг эрдэмтэд дурдсаар билээ. Энэ үеийн Монголын эзэнт гүрний гадаад бодлогын үндсэн гол зорилго нь монгол үндэсний эрх ашгийг дээдэлж улс орныхоо аюулгүй байдлыг хангах, эзэнт гүрний нэгдмэл байдлыг бэхжүүлэх явдал байлаа. Эзэнт гүрний бүрэлдэхүүнд байсан улс орнууд энэхүү зорилгод нийцсэн нэгдсэн гадаад бодлого хэрэгжүүлж байв. Чухамхүү Алтан ордоны улс, Цагаадайн улс, Ил хаадын улс, Юан улс хоорондоо найрсгаар хамтран бие биенээ дэмжиж байсны дүнд Евроазийн өргөн уудам нутаг дэвсгэрт өрнө дорнын худалдаа, соёлын харилцаа урьд байгаагүйгээр өргөн дэлгэр болж тухайн орнуудын хөгжил дэвшилд сүрхий нөлөөлж байлаа. Эзэнт гүрний бүрэлдэхүүн улсууд нь өвөр зуураа төдийгүй хил залгаа орнуудтайгаа улс төр, аж ахуй соёлын өргөн харилцааг чухалчилж байв. Цэрэг дайны бодлого нь тухайн улс орон бүрийн аюулгүй байдал, үндэсний эрх ашигтай нягт холбоотой байв. Юан улс төвийн болон баруун зүгийн улс орнуудтай харилцахдаа Ил хаант болон Алтан ордоны, Цагаадайн гэх мэт улсуудаар дамжуулж, тэдний дэмжлэгийг авч гадаад бодлогоо хэрэгжүүлж байсан бол өмнөд болон дорнодын орнуудтай шууд харилцаж байв. 1279 онд Өмнөд Сүн улсыг өөртөө бүрэн нэгтгэсэнээр эзэнт гүрний хүч нөлөө улам ихсч Өмнөд Сүн улсад алба өргөж байсан өмнөд хязгаарын бага буурай улсуудыг эрхшээл нөлөөндөө оруулах бодлогыг идэвхитэй хэрэгжүүлэв. Энэ нь Өмнөд Сүн улсын гадаад

* С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

бодлогын уламжлалыг үргэлжлүүлж буй мэт боловч тэр үеийн бага улс том гүрэнгэй найрсаг харилцаатай байх арга хэлбэр ийм л байжээ. Нэг үгээр хэлбэл бага буурай улс Их гүрний хаанд алба барьж үнэнчээ илэрхийлэх, их гүрний хааны эзэн эрхийг хүлээн зөвшөөрөх зэрэг нь тэр үеийн Алс Дорно дахины олон улсын харилцаанд үйлчилж байсан нэгэн гол зарчим бололтой. Тухайлбал Аннам улс Сүн улсад алба барьж байсан атлаа түүний өмнөд хөрш Чампа улс Аннам улсад алба өгч байсан гэх мэт. Хубилай хаан юуны өмнө Зүүн Өмнөд Азийн орнуудад өөрийн элч төлөөлөгчийг илгээж Их Юан улсын эзэн эрхийг хүлээн зөвшөөрүүлж дагуул хараат орон болгохыг шаардаж байсан нь Алс дорно дахинд нэгэнт тогтсон хэв журмыг л дагасан хэрэг байв. Тэгэхдээ тэр үеийн Монголын эзэнт гүрний гадаад бодлогын нэг зорилго нь тэнгэрийн үзэлд тулгуурлан дөрвөн далайн бүх улсыг нэгэн хааны эрхшээл дор байлгах явдал байв. Тийм учраас уг тогтсон хэв журмыг хэрэгжүүлэх нь Монгол гүрний гадаад бодлогын зорилгод яв цав нийцэж байсан тул хэрвээ бусад улс үүнийг эс хүлээн зөвшөөрвөөс хүч хэрэглэн хүлээн зөвшөөрүүлдэг арга зонхилж байв. Гэвч Хубилай хааны үеэс Монголын гадаад бодлого Чингисийн үеийг бодвол арай аядуу зөөлөн болсон гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэр үед бүх улс оронтой цус урсган дайтах нь гол биш ухуулан ятгаж энхийн аргаар эрхшээл нөлөөндөө оруулахыг ихэд хичээж байсан нь ажиглагдана. Энэ нь Хубилай хаан ор сууж улсыг захирахдаа төр ёсны арай нигүүлсэнгүй бодлогод шилжиж төрийн бодлогод арга бэлгийг хослуулсан “хос ёсны” үзлийг баримталж байсантай холбоотой.

2. Монгол ба Зүүн Өмнөд Азийн орнуудын худалдаа соёлын харилцаа

Өмнөд Сүн улсыг нэгтгэсний дараа Хубилай хаан Зүүн Өмнөд Азийн вант улсуудыг ээлж дараалан өөрийн хараат буюу дагуул орон болгосон тухай ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргасан “Монголын Эзэнт гүрний гадаад харилцаа” хэмээх бүтээлд нэлээд дэлгэрэнгүй танилцуулсан билээ.¹ Энэ удаа Монголын Юан гүрэн ба тухайн улс орнуудын хооронд худалдаа соёлын харилцаа ямаршуухан байсан талаар товч дурдахыг хичээв. Өмнөд Сүн улсыг эзлэн авч нэгтгэхийн төлөө олон жилийн дайн дажинд сүйрсэн эдийн засгийг сэргээхийн төлөө Юан улс нэн анхаарч олон чухал арга хэмжээ авсаны дотор худалдаа, зам тээврийн ажлыг ихэд анхаарав. Юуны өмнө Юан улсын төрөөс далайн худалдааг ихэд чухалчилж 1278 онд Монгудай, Сугату нарыг томилж өмнөд хятадын фучжоу боомтын худалдааг хянаж тэндээс гадаад арилжааг өргөжүүлэх ажлыг удирдуулсан байна. Мөн далайн эргийн Цюаньчжоу, Циньюань, Шанхай, Хамфу зэрэг томоохон хотуудад арилжааны төв нээв.² XIII

зууны сүүлийн хагаст далайн замын худалдаа өргөжиж өмнө зүгийнхэний газар зүй цаг уурын мэдлэг ч ихэд хөгжиж хэдэн мянган бээр аялдаг болсон тул Энэтхэг төдийгүй Араб, Перс, Газрын Дундад тэнгисийн бараа таваар Өмнөд Хятадад нэвтэрч Хятадын бараа ч тэр зүг чиглэх болсон нь Юан улсын анхаарлыг татахгүй байж чадсангүй.

Сугат жанжинд Хубилай хаан бичиг илгээж “Өмнөд хятадын усан боомтонд ирж худалдаа хийж буй гадаадын зорчигчид үнэн сэтгэлээр ордонд бараалхвал тэдэнд соёрхол хайрлаж худалдаа арилжааг чөлөөтэй хийлгэнэ” гэдгийг зарлан мэдээлэхийг даалгаж байснаас³ үзвэл тэр үед Юан улс далайн худалдаанд идэвхитэй оролцож дэлхийн олон улс оронтой өмнөд далайгаар харилцахын чухлыг нэн сайн ойлгож байжээ. Сүн улсыг нэгтгэж авснаар Эзэнт гүрэн далайн худалдааны том гүрэн болох гэсэн чанад бодлого байсан ч байж магад. Тэд умард хятадыг өмнөд хятадтай усан замаар холбож амуу тариа зөөвөрлөх болон худалдаа арилжааны хэмжээг үлэмж нэмсэнээс гадна далайн онгоцыг нэн олшруулжээ. Энэ явдал өмнөд далайн орнуудтай харилцахад дөхмийг үзүүлэв. Юан улсын усан онгоц өмнөд хятадын Цюанчжоу, Фуцзянь-ы усан боомтоос Энэтхэг-Хятадын хойгийн боомтуудад нэвтэрч очих нь олширч байв. Тухайлбал өмнөд хятадын гадаад худалдаа хийхэд зориулагдсан олон улсын худалдааны боомт Цюанчжоу-д Фулянь хэмээх сартуул эр хувьдаа ная гаруй онгоцтой, түүгээрээ өмнөд далайн боомтуудад очиж худалдаа хийдэг байжээ. Тэр үеийн Энэтхэг-Хятадын хойг дахь Хайфон, Хуй-Ан, мөн Индонез, Малайзийн боомтуудад тэдгээр онгоц бараа тээвэрлэн очиж Энэтхэг, Араб, Перс болон өмнө зүгийн ховор живэр барааг эргүүлэн зөөж байв. 1295 онд буюу Өлзийттөмөр хааны I онд монголын элч нарын бүрэлдэхүүнд орж Комбож улсад очсон Чжоу Дагуань гэгч далай тэнгисийн сайн мэдлэгтэн нанхиад хүн бичсэн нь “Бид Ханчжоу-гаас усан онгоцоор умар зүгийн салхины аясыг даган хөвсөөр Фуцзянь, Гуандун, Аннамын эрэг, Жампа улсыг дайран Комбожийн нийслэлд Улаан бичин жилийн долоон сард хүрээд өмнө зүгийн салхины урсгалыг хүлээн Да-дэ-гийн Улаагчин тахиа жилийн 6 сард сая буцав” гэжээ.⁴ Үүнээс үзвэл тэр үед далайчдын газар зүй, цаг уурын мэдлэг ихэд тэлж умрын болон өмнийн салхины урсгалыг чадамгай ашиглан хэдэн мянган бээр төвөггүй аялдаг байжээ. Мин улсын эхэн үед Чжэн Хэ гэгч далайчин Энэтхэгийн далайгаар эсэн мэнд амжилттай аялсан нь Юан улсын үеийн усан онгоцны үйлдвэрлэл ба далайн худалдааны хөгжилтэй шууд холбоотой юм.⁵

Юан улсын үед Зүүн өмнөд Азийн орнууд дагуул улс болсныхоо нотолгоо болгож өргөл бэлгийн чанартай алба барьж байв. Ийм алба нь ихэнх тохиолдолд тухайн үеийн бараа солилцоо, худалдааны үүрэг гүйцэтгэж байсныг судлаачид нэгэнт нотолсон билээ.

Тайландын хаан монголд нэгэн үе жил тутам, зарим үед гурван жилд нэг удаа элчээ илгээж Хаанбалгаст (Бээжин) ирээд Хубилай хаанд бэлэг өргөл барьж бар, заан, тогос зэрэг халуун орны амьтан, зааны соёо, хярсны эвэр, сармагчны тархи гэх мэт ховор эд зүйл өргөн барьж байв. Үүний хариуд Юан улсын хаан торго дурдан зэрэг барааг бэлэг болгон өгч байжээ. Тайландын хаан Рама Камхенг Юан улстай харилцахдаа их идэвхи санаачилга гаргаж хамгийн дотно харилцаж байсан тухай Лондонгийн Их сургуулийн профессор Дж.Холл 1950-иад онд туурвисан “Зүүн Өмнөд Азийн түүх” хэмээх томоохон суурь бүтээлдээ тэмдэглэсэн байдаг.⁶ Мөн Тайландын түүхч М.Л.Маних Жамсай “Хубилай хаан Рама Камхенг хааны анд найз байлаа” гэжээ.⁷ Юан улсаас тайландчууд гар урчуудыг олноор аваачиж байсныг түүхэнд тэмдэглэжээ. Түүний дотор шаазан ваарны урчуудыг Тайландад авчирсан нь хожим Тайландын Саванкалокийн алдарт шаазан эдлэлийн гар урлал хөгжих үндэс суурь болсон түүхтэй.⁸

Рама Камхенг хаан Монголын хаанд элчээ байнга илгээж байхдаа тэр үеийн заншил ёсоор гадаад худалдааг идэвхтэй өрнүүлж байжээ. Ялангуяа хил хязгаараа тэлэн өмнөд далайд гарцтай болсныхоо дараа Араб, Газрын дундад тэнгис, Өмнөд Азийн худалдааны зам харилцаанд холбогдон тэндэхийн барааг Юан улсын зах зээл рүү оруулж, тэндээс эргүүлж бараа аваачиж улмаар өмнөд Ази, Дундад Ази руу дамжуулахад зүүн өмнөд Азийн бусад, орны адил идэвхтэй оролцох болжээ. Төв болон зүүн Азийн эх газрыг хамарсан Юан улс торгон замыг гартаа авч өрнө дорно зүгт хийх худалдааг хөхиүлэн дэмжиж чөлөөтэй нэвтрэлцэх болсноор дэлхийн олон улс хоорондын худалдаа идэвхижсэн билээ. Үүний зэрэгцээ өмнөд далайн олон улсын худалдааны зам харилцаа ч идэвхижиж ирсэн байна. Тухайлбал Индонез, Малайз, Чампа, Аанамд Араб, Перс, Энэтхэг зүгийн худалдаачид олноор очих болжээ. XIII зууны Аннамьн гол бараа бол зандан агаруу зэрэг элдэв үнэт мод, зааны яс, хярсны эвэр, цагаан давс, энэтхэг болон Явын арлын бөс бараа байжээ. Юан улс, Бирм улсын харилцаа, ялангуяа худалдааны харилцаа Сүн улсын үеэс илүү өргөн байсан тухай Бирмийн түүхийн ном сударт тэмдэглэсэн байна.⁹

Комбож, монголын хооронд худалдаа арилжааныхан усан болон хуурай замаар чөлөөтэй зорчдог байжээ. Түүхэн сурвалжаас үзвэл 1320, 1329 онуудад хоёр улс элч солилцож, Комбожийн элч Монголын хаанд сургаж номхруулсан заан хүргэж байсан байна. Ер нь Комбожийн элч нар монголын хаанд бараалхахдаа үнэрт мод (агар-буюу зандан) заан, цагаан сармагчин, ирвэс зэрэг халуун орны ховор амьтан өгч байсан ажээ. Тэр үеийн элч төлөөлөгчдийн тэмдэглэлд дурдснаар Комбожийн худалдаачид Юан улсаас шаазан, торго дурдан авдаг байсан ба Комбожийн олсон нэхмэл, ёрог бөс даавуу, сийрсэн эдлэл, зааны соёог умард газрын худалдаачид сонирхдог байжээ.

Индонез, Юан улсын худалдааны харилцаа нилээд өргөн байсан бололтой. Энэ тухай Марко Поло “Зайтон (Цюань Чжоу), Манз (өмнөд хятадын)-ийн худалдаачид очиж их баялгийг аваачина” гэж тэмдэглэсэн бий.¹⁰ Чампа улс Их хаанд жил бүр хамгийн том 20 заанаар алба өргөж байв хэмээн Марко Поло тэмдэглэжээ.¹¹ Хубилай хаан ор суумагц 1261 онд газар тариалангийн албыг шинчлэн байгуулж амуу будааны ургац нэмэгдүүлэх олон арга хэмжээ авсан билээ. Энэ үед Зүүн Өмнөд Азиас гурвалжин анжис нэвтрүүлсэн нь чухал үүрэг гүйцэтгэв.¹² Мөн үед Юан улсын газар тариалангийн ололт Зүүн Өмнөд Азид нэвтэрч байв. Ялангуяа газар тариаланг усжуулах ажил Юан улсад нэн өрнөсөн нь хил залгаа орнуудад тун удалгүй нөлөөлжээ. Юан улс бүх улс орны хэмжээгээр суваг далан байгуулах ажлыг зохион байгуулах үед Аннамьн хил залгаа Дали болон Бирмийн умард мужуудад мөн усжуулсан тариалантай болж өмнө зүгийн мужуудад үерийн аюулаас сэргийлэх ажлыг анхаарч үерийн далан ихээр байгуулсан. Эдүгээ эртний Дали улс буюу одоогийн Юннань мужид монгол даргач Шамс Уд-динь-ий нэр алдартай холбоотой хиймэл нуур, Дээд Бирмд Юан улсын цэргүүд газар тариаланд зориулан байгуулсан томоохон далан ба усан сувгийн ул мөр одоо хүртэл байна.

Улаа өртөө нь Эзэнт гүрний үед нэгэнт хөгжлийн өндөр түвшинд хүрсэн байв. Чингисийн үед Умард хятад ба баруун оронд нэвтэрсэн улаа өртөөний замтай байсан бол Өгөөдэй хаан Хар Хорумд нийслэлсний дараа албан ёсны өртөөний дүрмийг хэрэгжүүлж Хар хорумаас Дунд Ази, Хятадын умард хэсэгт нэвтрэх замыг боловсронгуй болгосон, Өмнөд Сүн улсыг дайлсаны дараа Юан улс даяар өртөө замын тоо үлэмж нэмэгдэж Бирм, Вьетнам зэрэг Энэтхэг-Хятадын хойгийн улсуудад мөн л ийм улаа өртөө хэрэглэж шуурхай захидал, элч төлөөлөгч зэргийг дамжуулж байв. Өнөөг хүртэл Вьетнамд өртөө зам хэмээх үгний зам (жам) хэмээх үг замын өртөө, станц гэсэн утгаар үлджээ.

Тэр үед Европ, Араб, Төв Ази Хятад, Өмнөд Азийнханы хооронд соёлын харилцаа хөдөлгөөнд орж харилцан нөлөөлөх явц эрчимтэй болов. Үүнд бурханы шашин чухал нөлөө үзүүлсэн юм. Зүүн Өмнөд Азид НТ-ын эхнээс бурханы шашин Энэтхэгийн орноос дэлгэрч оюун сэтгэлгээнд нь гүн гүнзгий нөлөөлсөн билээ. Эхлээд бурханы шашны их хөлгөний урсгал Х зууныг хүртэл Зүүн Өмнөд Азийн орнуудад ихэд дэлгэрч байгаад дараа нь Арслан тивээс (Шриланка) бурханы шашны бага хөлгөний (тревада) урсгал нэвтэрч төрийн шашин болсон түүхтэй. Юан улсаас Зүүн өмнөд Азийн орнуудтай харилцаж эхлэх тэр үед Аннамьн хувьд бурхны шашны их хөлгөний урсгал улам хүчээ авч байв. Исламын шашин Арабын хойгоос Энэтхэгийн далайгаар дамжин Малайн хойг, Ява суматрын арал, энэтхэг-хятадын хойгт нэвтэрч байв.

Тэр үед Юан улсын төрөөс бурхны шашныг төрийн шашин болгож дээдлэхийн хамт бүх шашныг хүндэтгэн үзэж байсан билээ. Ийнхүү төв ба

Зүүн Өмнөд Азид шашны нэр хүнд, нөлөө ихэсч байх үед Зүүн өмнөд Азийн эх газрын хэсэгт мөн бурхны шашин (хэдийгээр өөр урсгал ч гэсэн) хүчээ авч байсан явдал шашин суртахууны харилцаа өргөжихөд нөлөөлжээ. Тийм учраас Юан улс, Энэтхэг-Хятадын хойгийн орнуудын хооронд лам хуврагууд харилцан зорчиж, ном судар солилцох явдал цөөнгүй байв. Аннамьн эртний түүхийн сурвалжид: “Нян Тон хааны үед (1279-1293) Ху нарын нутгаас Зүжибалам хэмээх ламтан ирэв. Ламтан өөрийгөө 300 настай гэх бөгөөд усан мандалд завилан сууж чадна. Бас гэдсэн доторхи таван цулаа огшоож цээжиндээ хурааж чадмой. Ийнхүү мэхийхдээ гэдэс бөөр нь нийлж зөвхөн арьс яс л үлдэнэ. Хэдэн жил болоод нэг будцуй. Ламтаны охин Далатхань-ыг хаан авч ордонд суулгав. Ламтан ордонд өөд болов. Минь Тон (1314-1329) хааны үед Ху нарын лам Бодэтхатли манай оронд ирэв...” гэх мэтээр дурдсан зүйл тааралдах ажээ.¹³ Энэ нь умар зүгийн лам хуврагууд өмнө зүгт мөн өмнө зүгийн лам нар умар зүг очиж ном эрдмээ дэлгэрүүлж байсаны нэг гэрч юм.

Юан жэн-гийн анхдугаар оны (1295) хөхөгчин хонин жил Юан улсын элч нар Аннамд бурханы шашны гурван аймаг савын номыг (трипитака) бэлэглэснийг Аннам ван олон мянган хувь барлаж Юан улсын Да дэ-гийн гуравдугаар оны шарагчин гахай жил (1299) дуусган улс даяар барлан тархаасан хэмээн мөн сурвалжид дурдсан байна.¹⁴ Мөн 1284 онд Хубилай хаан Шриланкад олон хүнтэй элчийг илгээж, тэнд хадгалагдаж байсан бурхан багшийн онгоноос дээж авчрах үүрэг өгчээ. Элч нар нутгийн хаанд бараалхаж ихэд мөргөж гуйсны эцэст тэрхүү дээжийг бурхан багшийн ногоон хаш тагш, үс, тэргүүтэн, аваад нутгийн зүг буцаж Хаанбалгаст ирсэн түүхтэй. Бурханы шашны мандал хийгээд махбодийн сургаал, арга билэг хосолсон төр ёсны үзэл гэх мэт Зүүн Өмнөд Азийн ард түмний олон зүйл бидэнтэй нийтлэг юм. Монгол ба Зүүн Өмнөд Азийн ард түмнүүдийн оюун санаанд бурханы шашны үзэл суртахуун гүн шингэж нийгмийн суртахууны нь үндэс суурь болсон тул харилцан бие биенээ ойлгох ойртон түншилж орчин үед хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дөхмийг үзүүлэх үндэс суурь болсоор байна.

Бурханы шашны гол цадиг сургаалуудаар дамжин Монгол ба Зүүн Өмнөд Азийнханы утга зохиол урлагт нийтлэг буюу адил төстэй санаа сэдэв утга өгүүлэгдэхүүн бүхий бүтээл туурвил арвин байгааг өмнөх судалгаанд нэгэнт дурдсан¹⁵ тул энэ удаа давтан өгүүлэхийг эс түвдэв.

Эртний Чампа улсын нутаг дэвсгэрээс энэтхэг соёлын нөлөө гүн гүнзгий байсны нотолгоо болсон гоёмсог гуулин бурхад олддог бөгөөд тэр нь IV зууны Энэтхэгийн Амараватийн соёлтой нягт холбоотой ажээ.¹⁶ Жич энэ соёл XVIII зуунд Төвдөөр дамжин Монголд мөн уламжлан ирсэн байхыг үгүйсгэх аргагүй юм.

Монголчууд өрнө дорнын олон улсыг нэгтгэснээр олон үндэстэн угсаатны соёлын нөлөөг өөртөө шингээн ахуй соёлын хувьд хөгжин

дэвшиж байсан нь мэдээж билээ. Монголчууд “хавирага газрыг халцаргал, өвдөг газрыг үлтэртэл” дэвхцэн бүжиглэдэг уламжлалтайг сурвалж бичгүүдэд дурдсан байдгаас гадна дуу хуурын эртний баялаг уламжлалтай. Энэ урлаг Юан гүрний үед улам дэлгэрэн хөгжиж хэлбэр агуулга нь баяжсан билээ. Тэр үеийн буюу Юан Жи юан-ы 5-р оны (1268) нэгэн явдлыг түүхэн сурвалжид бичсэн нь “Аннам-ын хаан өөрийн хөвүүн Ху нарын бүжиг бүжиж байгааг хараад цагаан бөс цамцаа тайлан өгч урамшуулхад отгон хан хүү тэр цамцыг авахын тулд мөн дуурайн бүжив” гэжээ.¹⁷ Ху нар гэдэг нь хятад ба вьетнамын ойлголтоор Дундад улсын умар зүгт орших хятад бус овог аймгуудын ерөнхий нэр билээ.

Юан улсын үед ордоны дуу бүжиг улам хөгжсөний нэг төрөл нь ордоны аялгуут жүжиг байлаа. Энэ тухай өрнө дорнын эрдэмтдийн судалсан зүйл нэн их билээ. Монголын сурвалжит хаад ноёд хятадын уламжлалт дуулалт жүжгийг сайшаан соёрхож хөгжүүлэхдээ монголын ноёрхолын үеийн нийгэм улс төр, ахуй соёлын онцлогт тохируулан монголын баатарлаг сүрлэг эрэмгий дуу бүжиг жүжгийн нөлөөг тусган хөгжлийн цоо шинэ шатанд гаргасан ажээ. Юан улсын үеийн дуулалт жүжиг бол тэр үеийн утга зохиолын хөгжлийн илэрхийлэл төдийгүй урлагийн олон хэлбэрийг нэгтгэн багтаасан цогцолбор урлаг болон хөгжсөн юм.

Юан улсын Сугат жанжины цэргээс олзлогдон үлдсэн нэгэн дуучин хүн Вьетнамын хааны ордонд умар зүгийн дуулалт жүжгийг тархаасан тухай “Их Вьет гүрний бүрэн тэмдэглэл”-д дурдсан нь: “Тэрбээр жүжиглэн дуулахдаа гоц авьяастай. Хар бар жилийн хавар хааны ордонд хатагтай гүнж нарыг зугаацуулах наадам үзүүлэх уралдаан зарлахад баатар жанжин түшмэд тэргүүтнийг төлөөлсөн 12 хүнийг оролцуулсан дуут жүжиг найруулан тоглов. Тоглогчид хээ хуар бүхий торгон өмсгөл өмсч бөмбөр цохин лимбэ үлээж, хуур наадан алга ташин гарч орон солигдож дуулж жүжиглэнэ. Үзэгч олныг уйтгарлуулж ч чадна, баясуулж ч чадна. Манай улсад тэр цагаас Туонг хэмээх дуулалт жүжиг буй болов” гэжээ.¹⁸ Тэрхүү “Туонг” хэмээх сонгодог театрын төрөл Вьетнамд одоог хүртэл хөгжиж ирсэн бөгөөд үүнийг үүсгэн бий болгоогүй юмаа гэхэд өмнө зүгийн оронд үндэсний дуурь мэт дуулалт жүжгийг хөгжүүлэх үйлсэд багагүй хувь нэмэр оруулсан нь илт байна.

Мөн Тогоон жанжны довтолгооны үед вьетнамд олзлогдсон цэргийн нэгэн эмч Вьетнамын хааны ордонд насаараа өвчтөнийг анагаан тусалж байсан бөгөөд түүний хүү бас л эцгийн ажлыг залгамжилж нэртэй оточ болсоныг мөнхүү “Их Вьет улсын бүрэн тэмдэглэлд” дурджээ. Ер нь Хубилай хааны үед монголын уламжлалт эмнэлгийн ухаан хятад болон бусад орны эмнэлгийн арга ухаантай хослон баяжиж хөгжлийн илүү шинэ түвшинд хүрсэн нь маргаангүй бөгөөд зүү тавих арга ихэд дэлгэрч байсан түүхтэй. 1305 онд монголын хаан вьетнамын хаанд “Эм тан ба зүү тавьж өвчнийг анагаахуй” номыг

өгч байсан мэдээ байгаа нь зүүн эмчилгээ муугүй хөгжсөн байсныг харуулж байна.¹⁹

XIII зууны сүүлийн хагаст Юан улсаас Зүүн өмнөд Азийн орнуудад очиж байсан элч төлөөлөгч нараас тухайн үндэстний ахуй байдал, ёс заншлыг тэмдэглэсэн ном бичиг үлдээсэн нь цөөнгүй байна. Тухайлбал: Комбожийн Заяварман VIII (1243-1295) хааны үед Хубилай хааны элч нар Комбожид очиход нийслэл Ангкор хотод 1 жил (1296-1297) саатан суухдаа түүний бүрэлдэхүүнд явсан Чжоу Дагуань хэмээх хүн тэр үеийн Комбож орны тухай, Ангкор хотын тухай үнэ цэнэтэй, томоохон тэмдэглэл бичиж үлдээсэн нь эдүгээ комбожийн судлалд чухал хэрэглэгдэхүүн болсоор байна. Тэр тэмдэглэлийн “Бичиг үсэг” хэмээх гарчигтай хэсэгт нэгэн сонирхолтой зүйлийг Чжоу Дагуань дурджээ. Тэнд бичсэн нь “Хар маажингаар будсан буга согооны арьсан дээр цагаан шохойгоор үсэг бичгээ бичнэ. Тэр нь удтал үл арилна. Нойтон зүйлээр арчиж арилгана. Үсгийн хэлбэр нь уйгур үсэгтэй адил. Үсэг холбож үгийг бичихдээ дээрээс доош биш хойноос урагш бичнэ. Сэчинхаяа (цуг очсон монгол элч нарын нэг) надад хэлэхдээ үсгийн хэлбэр ба авианы дуудлага нь монголтой адил бөгөөд ганц хоёрхон үсэг зөрж байна хэмээсэн билээ” гэжээ.²⁰ Яагаад тэр үед комбожид уйгур үсэгтэй адил үсэг хэрэглэж байсныг ойлгоход хэцүү юм. Тэр үед Комбож улс бурханы шашинтай байсан бөгөөд эртний энэтхэг гаралтай пали самгарьд үсэг хэрэглэж байсан байлтай. Гэтэл цуг очсон монгол элч нотлон хэлэхдээ уйгур монгол үсэгтэй адил бөгөөд ганц нэгхэн үсгийн дуудлага зөрж байна гэсэн нь нэн сонин юм. Зүүн Өмнөд Азид Араб Персээр дамжин VIII-XII зуунд лалын шашин нэлээд эрчимтэй тархсан түүхтэй. Тийм учраас Жанла буюу Комбож улсын хааны ордонд тэр үед араб үсэг мэр сэр хэрэглэж байсан байж болох юм. Гэвч миний бие энэ тухай мэдээ материал хараахан олж үзсэнгүй.

1330 онд Бирмд, 1349 онд Малайзид монголын элч нартай очсон Юан улсын газар зүйч, худалдаачин Ван Даюань-ы бичсэн “Арал хойгийн харь үндэстний тэмдэглэл” гэдэг номонд одоогийн Бирмийн өмнөд мужуудын тухай тодорхой бичсэнээс гадна, одоогийн Сингапур хотын тухай сонирхолтой тэмдэглэл бий.²¹

Үүнээс гадна 1289 онд Вьетнамын нийслэл Тханг Лонг-д очсон монголын элч Ты Минь Тянь “Аннамд зорчсон тэмдэглэл” бичсэн бөгөөд энэ тэмдэглэлд вьетнамын сурвалж бичгүүдэд болон Юан улсын судрын Аннамдын түүхийн хэсэгт ер тэмдэглэгдээгүй Вьетнамын хаан, Хубилай нарын харилцсан бичиг захидлуудын тухай байдаг ажээ. Бас 1291 онд Вьетнамд очсон Чанфу гэгч элчийн тэмдэглэлд вьетнамын тухай шүлгээс гадна XIII зууны вьетнамын нийгэм, эдийн засгийн холбогдолтой чухал мэдээ баримт орсон байна.²²

1285 онд Туган жанжинаар удирдуулсан их цэрэг Аннамдын нийслэлийг эзэлж зүүн өмнө зүгээс Сугату жанжинаар толгойлуулсан

их цэрэг хүч хавсран довтлох үеэр Аннамын зарим цэргийн эрхтэн болон хааны удмын хэсэг хүмүүн Юан улсад дагаар оржээ. Тэдний дотор Аннамын бичгийн түшмэл Ле Чак байсан бөгөөд Юан улсад түшмэлийн алба хашиж байгаад хожим нь насан өөд болтлоо бичиг номын ажилд шамдан “Аннамын товч тэмдэглэл” хэмээх сурвалж бичгийг 1330-аад онд бичиж үлдээсэн байна.²³

Энэ түүхийн сурвалж бүгд 20 дэвтэр бөгөөд Аннамын тэр үеийн байгаль цаг уур, зан заншлаас эхлээд цэрэг цуух, гадаад дотоод хэргийг нэн бодитой тэмдэглэн үлдээснээс гадна тэр үеийн Юан гүрэнтэй харилцаж байсан бичиг захидалын зүйл, элч төлөөлөгч солилцож байсан он цагууд, тэр үеийн цэрэг дайны ажиллагааг тов тодорхой өгүүлснээрээ Монголын түүхэнд чухал ач холбогдолтой юм. Энэ сурвалжид Юан улсаас Аннамын хаанд илгээсэн 18 зарлигийн бичиг, мөн Аннамын хааны өргөсөн бичиг, элч нарын 20 гаруй шүлэг байгааг миний бие орчуулж хараахан дуусаагүй байна. Энэ нь Монгол, Вьетнамын харилцааны түүхийн чухал сурвалж материал билээ.

Үүнээс гадна Зүүн өмнөд Азийн нутагт XIII зууны монголын түүхэнд холбогдох түүх дурсгалын зүйл мэр сэр үлдсэн байна. XIII зуунд монголын цэрэгтэй байлдаж ялсан Аннамын цэргийн жанжин Чан Хынг Дао-гийн шүтээний сүм, үүний бичээс одоо умард вьетнамын Хайзыонг мужийн Тхү-кхе гацаанд бий. Мөн монгол, вьетнамын цэргийн тулалдааны тухай шүлэглэн сийлсэн хадны бичээс Вьетнамын зүүн тэнгисийн нэгэн булангийн Зыонг Ням хэмээх ууланд байна. Мөн дээр өгүүлсэн Чжоу Дагуань-ий дурсгалын агуй Комбожд бий.

1288 онд Аннамын цэрэг Монголын усан цэрэгтэй тулалдах үед хэрэглэж байсан аварга том занга моднууд голын ёроолоос одоо хүртэл олдсоор байна. Вьетнамын археологичид уртаараа 2,50-2,93 метр, бүдүүнээрээ 0,26-0,86 метр голчтой хэд хэдэн ийм модон шонгуудыг 1984 онд олсон бөгөөд далайн ёроолд зоолттой хэвээр байжээ.

XIII зууны Монгол ба Зүүн өмнөд Азийн улсуудын харилцааг бүхэлд нь авч үзвэл Монголын эзэнт гүрнээс Зүүн Өмнөд Азийн улс орнуудтай харилцахдаа өөрийн дагуул хараат болгохын тулд үгээр сүрдүүлэн дагаар орохыг ятгах, эс дагаваас хүч хэрэглэн дайн дажин үүсгэх явдал байсан боловч тэдгээр улстай худалдаа, улс төр, соёлын харилцааг аль болохоор бий болгохыг зорьжээ. Энэ нь Монголын эзэнт улс ба Зүүн өмнөд Азийн улс үндэстнүүдийн аж ахуй, соёлын хөгжилд таатай нөлөөг үзүүлсэн байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. “Монголын Эзэнт гүрний гадаад харилцаа (XIII-XIV)” Ред. Н.Ишжамц, С.Дашцэвэл, М.Хурметхан. УБ. 1995. 98-117-р тал.
2. Юан улсын судар (Дандаагийн орчуулга) 210-р дэвтэр.
3. Мөн тэнд, 10-р дэвтэр. На Van Tan, Pham Thi Tan. Cong cuoc khang chien chong xam luoc Nguyen Mong cua the ky XIII. На Noi, 1972. tr.123.
4. Chu Dat Quan, Chan Lap phong tho ky. Hanoi. 2006, 24-р тал.
5. Чжэн Хэ. Наньжин да шүэ чү бан шэ. 1990.
6. Дж.Холл. История Юго-Восточной Азии. М., 1958. с.133
7. M.L.Manich Jamsai. Popular History of Thailand, Bangkok, 1980. p.102.
8. Э.О.Берзин. Юго-Восточная Азия в XIII-XIV веках. М.1982. с.17.
9. Хэ Шэньда. Мянъян ши, Бейцзин. 93-р тал.
10. Марко Поло, Орчлонгийн элдэв сонин. УБ. 1987, 193-р тал.
11. Мөн тэнд 192-р тал.
12. Монголын Юан улс. УБ. 2006, 58-р тал.
13. Ngo Si Lien. Dai Viet su ky toan thu. Tap II, Ha Noi, 1967, tr.99-р тал) (Их Вьет гүрний түүхийн тэмдэглэлийн бүрэн дэвтэр. II)
14. Мөн тэнд. 73, 79-р тал. Le buoddisme au Vietnam, Hanoi, 1993, p.110)
15. С.Дашцэвэл. Төв Ази ба Зүүн Өмнөд Азийнханы түүх-угсаатны соёлын харилцаа. “ОУС” сэтгүүл. УБ. 2008, №3.
16. J.Boisselier. La statue de Champa. EFEO, Paris, 1963, p.24.
17. Ngo Si Lien. Dai Viet su ky toan thu. Tap II, 37-р тал)
18. Мөн тэнд, 148-р тал.
19. Мөн тэнд, 91-р тал.
20. Chu Dat Quan, Chan Lap phong tho ky. Hanoi, 2006, 39-40-р тал
21. R.O.Winstedt. A History of Malay. Kuala Lumpur, 1968.
22. Tap chi van hoc. Ha Noi, 1972. №1 tr.112.
23. Le Trac. Annam chi luoc, Hue .2006.